Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

**Swiss Agency for Development and Cooperation SDC**

МОНГОЛЫН БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХОЛБОО

# "ЗУДЫН ХОХИРЛЫГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ" ТУСЛАМЖИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАРЫН АВЛАГА

*Бэлчээр ашиглагчдын хэсгийн ахлагч нарт зориулав*



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

**Swiss Agency for Development and Cooperation SDC**

**МОНГОЛЫН БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХОЛБОО**

# "ЗУДЫН ХОХИРЛЫГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ" ТУСЛАМЖИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАРЫН АВЛАГА

***Бэлчээр ашиглагчдын хэсгийн ахлагч нарт зориулав***

..................... аймгийн ........................ сумын
"................................" БАХ

**Улаанбаатар**
**2010**

## "МОНГОЛЫН БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХОЛБОО" ТББ

**Холбоо барих утас, хаяг**

БЗД 3-р хороо, 12-р хороолол 13381, Их тойруу 49
Монголын Бэлчээрийн Менежментийн Холбооны байр
Зохиомж дээд сургуулийн залгаа гурван давхар байр

**Шуудангийн хаяг:** УБ-13, Төв шуудан, ш/х-2693
Утас: 70151458, 453747, 453703
Факс: 976-11-70151458, 453757
E-mail: msrm@magicnet.mn
Вэб: www.msrm.mn

**МБМХ-ны Хамтын Нийгэмлэгийн Хөгжлийн Алба**

1) Ж.Чанцаллхам /Албаны дарга/ утас: 99187947
1) Н.Ганхуяг /Мэргэжилтэн/ утас: 99703519
2) Ж.Баясгалан /Мэргэжилтэн/ утас: 99121245
3) З.Галмандах /Мэргэжилтэн/ утас: 99888393

# ӨМНӨХ ҮГ



1999-2000 онд тохиосон зудын гамшигт нэрвэгдсэн Монголын ард түмэнд туслах уриалгыг 2000 онд НҮБ-аас гаргасныг Швейцари улсын засгийн газар дэмжиж, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаагаа Швейцарийн Хөгжлийн Агентлаг /ШХА/-аар дамжуулан 2001 оноос тус оронд хэрэгжүүлж эхэлсэн билээ.

ШХА-ийн үйл ажиллагаа, зудын нөхцөлд буй малчид, малгүй болсон иргэд, ядуу болон нийгмээс тусгаарлагдсан хувь хүмүүст үзүүлэх тусламж зэрэг хүмүүнлэгийн тусламжийн хэлбэрээс хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөрт аажмаар шилжиж, үйл ажиллагаагаа илүү өргөн цар хүрээтэйгээр явуулж байна. ШХА-ийн үндсэн зорилго бол, экологиийн баримжаатай нийгэм-эдийн засгийн хөгжлийг үндэс болгон, байгалийн нөөц баялгийг үр ашигтай, тогтвортой ашиглах, хамгаалах замаар малчдын болон малгүй болсон иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, түүнийг баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх явдал юм.

Монгол улсын ерөнхий сайд С. Батболдын хэлсэнчлэн, энэ жилийн буюу 2009-2010 оны өвөл нь Монгол оронд сүүлийн 30 жилд ажиглагдаагүй хүнд хэцүү өвөл болж байна. Нийт нутаг дэвсгэрийн 90 гаруй хувийг хамарсан 20–90 см зузаантай цасан бүрхүүл тогтож, хүйтний эрч болоод үргэлжлэх хугацаа харьцангуй их, шороон болон цасан шуурга цөөнгүй тохиолдож буй, өвс тэжээлийн гарц муу зэрэг байгалийн хүндрэл бэрхшээлээс гадна хувь хүний болоод нийгмийн хүчин зүйлийн нөлөө зудын энэхүү байдалд нэрмээс болж байна.

ШХА-аас үзүүлж буй энэ удаагийн тусламжийн төслийг МБМХ болон орон нутаг дахь салбар болох сумын Бэлчээр Ашиглагчдын Холбоо ТББ-аар дамжин малчдын өөрийгөө удирдах байгууллага болох бэлчээр ашиглагчдын хэсгийн малчид та бүхэн өөрсдөө хэрэгжүүлэх юм. Энэхүү төсөл нь малчдыг эдийн засгийн хувьд дэмжиж, эмзэг бүлгийн малчдыг ядууралд орохоос урьдчилан сэргийлэх зорилготой хэдий ч хамгийн чухал нь малчид та бүхэнд ахуй амьдралаа хэрхэн сэргээн босгохоо шийдэх боломж, итгэл найдварыг өгч буй хүмүүнлэгийн, сэтгэл зүйн тусламж юм.

Малчид та бүхэндээ, хамтаараа зудын хүндрэлийг амжилттай даван туулж төслөө амжилттай хэрэгжүүлэхийг хүсье!



***Фэликс Фэллманн***
***ШХА-ийн Монгол дахь суурин төлөвлөгч***



Монгол оронд 2009-2010 оны өвөл байгалийн гамшиг болох зуд нүүрлэж, олон сая мал хорогдон, эдийн засгийн асар их хор хохирол учруулаад байна. Гэхдээ бэлтгэл сайтай байсан бол арай бага хохиролтой гарч болох байсныг та бүхэн мэднэ. Цаашид ч хэрхэн ажиллах талаар нэг ёсны сануулга болж өглөө. Хүнд хэцүү энэ үед хувь хүн, албан байгууллага, нутгийн зөвлөлөөс гадна дотоод гадаадын олон улс орны төсөл хөтөлбөрүүд байгалийн бэрхшээлийг даван туулахад тусламжийн гараа сунгаж байна. Үүний нэг нь Швейцарийн Хөгжлийн Аентлаг/ШХА/-аас хэрэгжүүлж буй 500 000 швейцарь франкийн өртөг бүхий "Зудын хохирлыг бууруулах, урьдчилан сэргийлэх"төсөл юм. Тусламжийн энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлэх, үр ашигтай зарцуулж зөв хуваарилах нь сумдын Бэлчээр Ашиглагчдын Холбоо Төрийн Бус Байгууллагын тэргүүнүүд, Бэлчээр Ашиглагчдын Хэсгүүд (БАХ)-ийн ахлагч нар, малчид та бүхний нэн хариуцлагатай үүрэг юм. Энэхүү төслийг нэгж салбарт үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд сумдын ТББ-ууд зохион байгуулах, хяналт тавих үүрэгтэй оролцох ба БАХ-үүд нь гишүүдийн хурлаараа хэрхэн ашигтай, зөв зарцуулахыг харилцан зөвшилцөж шийдвэрлэх юм. Энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлэх нь малчдыг зуднаас үүдэлтэй ядуурлалд өртөхөөс сэргийлэх, хохирлын хэмжээг бууруулах, улмаар БАХ-үүдийн малчдын хамтын зохион байгуулалтыг бэхжүүлэх, зудтай тэмцэх менежментийг сайжруулах боломцоог олгож байна. Энэхүү тусламжийн хөрөнгийг хамгийн үр ашигтай, ил тод, шудр ага хуваарилж ашиглах талаар ШХА-с Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо, сумын Бэлчээр Ашиглагчдын Холбоо, Бэлчээр Ашиглагчдын хэсгээр дамжуулан шийдвэрлүүлэхээр итгэл үзүүлж байгаад бид баяртай байна. Та бүхэн энэхүү итгэлийг дааж, төслийг амжилттай хэрэгжүүлнэ гэдэгт итгэж байна.

Та бүхэн зудыг гарз хохирол багатай даван туулах зөв арга замыг хамтаараа олж, оновчтой арга хэмжээ авна гэж найдаж байна. Та нарт ажлын их амжилт хүсье!



***Д. Дорлигсүрэн***
***МБМХ-ны гүйцэтгэх захирал***

# ТОВЧИЛСОН ҮГ

| | |
|---|---|
| АХ | Ажлын хэсэг |
| БАХ | Бэлчээр ашиглагчдын хэсэг |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| МБМХ | Монголын бэлчээрийн менежментийн холбоо |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ШХА | Швейцарийн Хөгжлийн Агентлаг |

# БҮЛЭГ НЭГ. БЭЛТГЭЛ ҮЕ ШАТ



## 1.1 Бэлчээр ашиглагчдын хэсгийн ахлагч нарын хурал

ШХА-аас зудын гамшигт нэрвэгдээд байгаа манай орны зарим аймаг, сумын малчдад хүмүүнлэгийн тусламж үзүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү тусламжийн хөрөнгийг гагцхүү ***малчдын оролцоотойгоор*** зарцуулах бөгөөд хяналт тавих үүрэг нь мөн адил байх юм.

Сумын “Бэлчээр ашиглагчдын холбоо” (СБАХ) ТББ-ын тэргүүнээр удирдуулсан анхны хуралд та нар оролцож, энэхүү төслийн хэрэгжүүлэх үе шатуудтай танилцана.

Энэхүү хурал дараах хэсгүүдээс бүрдэнэ:

| N | Үйл ажиллагаа | Хэн |
|---|---|---|
| 1 | Хурлын нээлт, танилцуулга | ТББ Тэргүүн |
| 2 | ШХА-гаас хэрэгжүүлж буй төслийн танилцуулга /поверпоинт компьютер танилцуулга - Хуудас 7– 9/ | ТББ Тэргүүн |
| 3 | Гарын авлагатай танилцах | БАХ Ахлагчид |
| 4 | Асуулт, хариултын хэсэг | Нээлттэй хэлэлцүүлэг |

Сумын “Бэлчээр ашиглагчдын холбоо” ТББ-ын тэргүүнээр удирдуулсан тусламжийн ажлыг зохион байгуулах, хяналт тавих зорилго бүхий Ажлын Хэсэг байгуулагдах болно. Ажлын Хэсэг нийтдээ 5 хүний бүрэлдхүүнтэй байна.

Ажлын хэсэгт дараах төлөөлөл зайлшгүй байна. Үүнд:

- Сумын төрийн байгууллага (Онцгой комиссын төлөөлөл)
- Багийн засаг дарга нарын төлөөлөл
- ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүдийн төлөөлөл

**(Хүснэгт1.) Ажлын хэсгийн гишүүдийн нэр, албан тушаал** *(ТББ-н тэргүүн бөглөнө)*

| N | Ажлын хэсгийн гишүүдийн нэрс | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|
| 1 | | | |
| 2 | | | |
| 3 | | | |
| 4 | | | |
| 5 | | | |

Он.......... Сар...... Өдөр.............

Баталсан: ........................../ / :................/ /

Сумын Засаг Дарга СБАХ ТББ-н тэргүүн

Ажлын хэсэгт орох гишүүдийн нэрсийг тогтож сумын бэлчээр ашиглагчдын холбоо ТББ-н тэргүүн, сумын засаг дарга нар баталгаажуулна.

***Ажлын хэсгийн гишүүдийн үүрэг хариуцлага:***

- Бүх БАХ-н ахлагч нартай хамтран суманд ирсэн зудын тусламжийн мөнгийг БАХ бүрт хуваарилах
- БАХ бүрийн төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах хуралд оролцож зөвлөгөө, тусламж үзүүлэх
- БАХ бүрт тусламжийн төслийн үйл ажиллагаа хэрхэн хэрэгжиж байгаа талаар хяналт хийж сумын бэлчээр ашиглагчдын холбоо ТББ-н тэргүүнд мэдээлэх

***БАХ-н ахлагч нарын үүрэг хариуцлага:***

- Суманд байгуулагдсан Ажлын хэсгийн гишүүдийн хамт БАХ-уудад хуваарилагдах тусламжийн төслийн мөнгөний хуваарилалтанд оролцох
- БАХ-н хурлыг хуралдуулан хүмүүнлэгийн яаралтай тусламж авах өрхийг тогтох, мөн БАХ-н малчид хамтаараа зудаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлэх
- БАХ-н ахлагчид зориулсан гарын авлагын хавсралтанд байгаа хүснэгтүүдийг бөглөж тайлангийн хамт хүргүүлэх

Хүмүүнлэгийн яаралтай тусламжийг зохих эзэнд нь үнэн зөвөөр хүргэхэд БАХ-н малчид та бүхний болон ажлын хэсгийн гишүүдийн хариуцлагатай байдлаас ихээхэн хамаарах тул та нарын үүрэг идэвхи зүтгэл хамгаас чухал билээ.

БАХ-д хуваарилагдан очиж байгаа тусламжийн мөнгөний 50 хувийг хүмүүнлэгийн яаралтай тусламжийн үйл ажиллагаанд зарцуулна. Тухайлбал: Малгүй болсон буюу нэн ядуу өрхөд тусламж үзүүлэх, түлш, хүнсний бүтээгдэхүүн, хүн, малын эм, тариа, өвс, тэжээл, төл малын сүү орлох тэжээл худалдан авах гм.

Үлдэх 50 хувийг дундын мөнгөн сан бүрдүүлэн зудын гамшгаас сэргийлэх арга хэмжээнд зарцуулах юм. Үүнд: Хадлангийн талбай хаших, хүнсний ногоо, малын тэжээл тариалах, зам, гүүр засварлах гаргах, худаг уст цэг гаргах, засварлах гм.

# 1.2. БАХ-н гишүүн малчдад хүргэх мэдээлэл




**2010.04.27**

**ЗУДЫН ХОХИРЛЫГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨСЛИЙГ ОРОН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ**




**Энэ төсөл яагаад хэрэгжих болсон бэ?**

- Монгол оронд 2009-2010 оны өвөл байгалийн гамшиг болох зуд нүүрлэж, олон сая мал хорогдон, эдийн засгийн асар их хор хохирол учруулаад байна.
- Энэхүү байгалийн бэрхшээлийг даван туулахад Швейцарийн Хөгжлийн Аентлаг/ШХА/-аас тусламжийн гараа сунгаж 450 000 швейцарь франкийн өртөг бүхий “Зудын хохирлыг бууруулах, урьдчилан сэргийлэх”төслийг хэрэгжүүлэхээр боллоо.




**Энэ төсөл яагаад хэрэгжих болсон бэ?**

- Тусламжийн энэхүү төслийг Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоогоор дамжуулж “Ногоон Алт” төсөл хэрэгжиж буй сумдын зудын хохирол хамгийн ихтэй байгаа сумдад хэрэгжүүлэхээр болоод байна.
- Тусламжийн энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлэх, үр ашигтай зарцуулж зөв хуваарилах нь сумдын Бэлчээр Ашиглагчдын Холбоо Төрийн Бус Байгууллагын тэргүүнүүд, Бэлчээр Ашиглагчдын Хэсгүүд (БАХ)-ийн ахлагч нар, малчид та бүхний нэн хариуцлагатай үүрэг юм.




**“Ногоон алт” төслийн сумдын өвөлжилтийн байдал**

*/Онцгой Байдлын Ерөнхий Газраас авсан мэдээ/*

| Аймаг | Гамшгийн байдалд байгаа сумд | Хүнд нөхцөлд байгаа сумд | Цаашид хүндэрч болзошгүй сумд |
|---|---|---|---|
| 1.Архангай | Их тамир | 2 сум | |
| 2.Баян-Өлгий | Булган | | Ногооннуур, Улаанхус, Цэнгэл |
| 3.Говь-Алтай | Алтай | Дэлгэр Бигэр | |
| 6.Завхан | 17 сумл | Баянхайрхан, Завханмандал, Тэс, Асгат, Ургамал | |




**Зудын хохирлыг бууруулах, урьдчилан сэргийлэх төслийн тухай**

- **Төслийн нийт санхүүжилт:** 500 000 Швейцарь Франк ба тухайн суманд байгаа малчин өрхийн тоо, зудын байдалд үндэслэж нэг суманд олгох санхүүжилт шийдэгдэж байна.
- **Төсөл хэрэгжих газрууд:** Нийт 20 сум. Үүнд: Завхан аймгийн 17 сум, Говь-Алтай аймгийн Алтай, Бигэр сумд, Баян-Өлгий аймгийн Булган сум, Архангай аймгийн Их Тамир сум
- **Төсөл хэрэгжүүлэгчид:** ШХА-с санхүүжүүлж Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо, Ногоон Алт төсөл хэрэгжиж буй дээрх сумдын Бэлчээр Ашиглагчдын Холбоо ТББ-ууд, Бэлчээр Ашиглагчдын Хэсгүүд өөрсдөө хэрэгжүүлэх юм.
- **Төсөл хэрэгжүүлэх хэлбэр:** Төслийн санхүүжилтийн 50%-г зудын гамшигт хамгийн их өртсөн малчдад БАХ-н малчдын хурлаар харилцан хэлэлцэж шийдвэрлэсэнээр олгох бөгөөд үлдсэн 50%-г зудын гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл үйл ажиллагаанд зарцуулах юм.




**Зудын төсөл хэрэгжүүлэх сумдын малын хорогдлын мэдээ**

*/Онцгой Байдлын Ерөнхий Газраас авсан мэдээ/*

| Сумд | 2009 оны эцэст тоологдсон мал | Хорогдол /3 сарын 22/ | Хорогд-лын хувь | Эрэмбэл-сэн байдал |
|---|---|---|---|---|
| Сонгино | 122614 | 57375 | 46.8 | 1 |
| Яруу | 141200 | 58128 | 41.2 | 2 |
| Шилүүстэй | 98799 | 37827 | 38.3 | 3 |
| Цагаанчулуут | 95030 | 34617 | 36.4 | 4 |
| Баян-Өлгий Булган | 127311 | 45886 | 36 | 5 |
| Алдархаан | 215809 | 72863 | 33.8 | 6 |
| Цагаанхайрхан | 81591 | 18557 | 22.7 | 7 |
| Отгон | 196995 | 43753 | 22.2 | 8 |
| Эрдэнэхайрхан | 55995 | 33083 | 21.2 | 9 |
| Говь-Алтайн Алтай | 69720 | 14700 | 21 | 10 |



"Ногоон алт" бэлчээрийн экосистемийн удирдлага төсөл

**Зудын төсөл хэрэгжүүлэх сумдын малын хорогдлын мэдээ**

*/Онцгой Байдлын Ерөнхий Газраас авсан мэдээ/*

| Сумд | 2009 оны эцэст тоологдсон мал | Хорогдол /3 сарын 22/ | Хорогдлын хувь | Эрэмбэлсэн байдал |
|---|---|---|---|---|
| Тосонцэнгэл | 154528 | 26088 | 16.9 | 11 |
| Их уул | 168133 | 31019 | 18.4 | 12 |
| Нөмрөг | 102102 | 13579 | 13.3 | 13 |
| Түдэвтэй | 105424 | 13945 | 13.2 | 14 |
| Архангай Их Тамир | 259083 | 32762 | 12.6 | 15 |
| Тэлмэн | 12437 | 15098 | 12.2 | 16 |
| Цэцэн-Уул | 116959 | 10253 | 8.8 | 17 |
| Сантмаргац | 10615 | 122795 | 8.6 | 18 |
| Говь-Алтайн Бигэр | 86675 | 6786 | 7.8 | 19 |
| Баянтэс | 101948 | 7314 | 7.2 | 20 |



"Ногоон алт" бэлчээрийн экосистемийн удирдлага төсөл

**Төслийг хэрэгжүүлэх үе шатууд**

- 1. Бэлтгэл үе шат
- 2. Хяналт, шалгалт
- 3. Тусламжийн төслийг хэрэгжүүлэх
- 4. Тайлагнал



"Ногоон алт" бэлчээрийн экосистемийн удирдлага төсөл

**I.Бэлтгэл үе шат**

| Үйл ажиллагаа | Оролцогчид | Хариуцах эзэн | Гарах үр дүн |
|---|---|---|---|
| 1.Зудын төслийн талаар мэдээлэл өгөх, танилцуулах | Сумдын ТББ-н тэргүүнүүд, туслах ажилтан, онцгой комиссын 1 гишүүн-нийт | МБМХ-Чанцал, Ганхуяг | Төслийг хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголттой болно |
| 2.Сумдад төслийн талаар танилцуулж, ажлын хэсэг байгуулах | Сумын онцгой комиссын гишүүд, БАХ-н ахлагчид | Сумын ТББ-н тэргүүн | Орон нутагт төслийг хэрэгжүүлэх талаар сайн ойлголттой болж Ажлын хэсэг байгуулагдах |



"Ногоон алт" бэлчээрийн экосистемийн удирдлага төсөл

**I.Бэлтгэл үе шат (үргэлжлэл)**

| Үйл ажиллагаа | Оролцогчид | Хариуцах эзэн | Гарах үр дүн |
|---|---|---|---|
| 3. Ажлын хэсэг хуралдаж БАХ-н бүрийн хурлын товыг тогтож Ажлын хэсгээс оролцох төлөөллийг тогтоно. | Сумын онцгой комиссын гишүүд, БАХ-н ахлагчид | Сумын ТББ-н тэргүүн, Ажлын хэсэг | БАХ бүр төслийн үйл ажиллагааны талаар нэгдсэн ойлголттой болох, оролцох. БАХ ахлагчид гарын авлага авсан байна. |
| 4. БАХ –ийн ахлагчид хурлын товыг гишүүн малчдад тараах, хурлыг зохион байгуулах | БАХ-н гишүүн малчин өрхүүд | БАХ-н ахлаг-чид, ТББ-н тэргүүн, АХ-н гишүүн | БАХ-н тусламжийн төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө төсвийн хамт гарна. БАХ-н зохих өрхүүд авах, зудын бэлтгэл ажил БАХ-н хэмжээнд хийгдэх төлөвлөгөө гарч, хэрэгжүүлж эхлэх |



"Ногоон алт" бэлчээрийн экосистемийн удирдлага төсөл

**II.Төслийн үйл ажиллагааны хяналт**

| Малчид хянах | Хэрхэн хянах вэ |
|---|---|
| 1. Төслийн холбогдолтой шийдвэр гаргалт нь малчдын санал оролцоонд тулгуурлаж буй эсэх | БАХ-н хуралдаа сайн оролцох /БАХ-н ахлагч хурлын ирцийг бүртгэх/ |
| 2. Малчдын хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн арга хэмжээнд зар-цуулж буй эсэх | Мэдээллийн самбарт шаардлагатай мэдээллийг БАХ-н ахлагч АХ, ТББ-н тэргүүнд сар бүр тогтмол явуулах |
| 3. Ажил үйлчилгээнд зарцуулсан мөнгө нь орон нутгийн үнэ ханштай нийцэж буй талаар | БАХ-н хурал дээр БАХ-н ахлагчийн тайлан, АХ-н тайланг сонсох |
| 4. Зарцуулалтын тайлан ил тод байгаа талаар | БАХ-н ахлагч, ТББ-н тэргүүний тайлагнал |
| 5. БАХ-ийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа хэр явагдаж байгаад | Тусламж хүлээн авсан өрхийн гарын үсгийн ард баталгаажуулсан байдал, БАХ-н хурал дээр мэдээлэл |



"Ногоон алт" бэлчээрийн экосистемийн удирдлага төсөл

**II.Төслийн үйл ажиллагааны хяналт (үргэлжлэл)**

| АХ, ТББ-ын Хянах | Хэрхэн хянах вэ |
|---|---|
| 1. БАХ-уудын тусламжийн төслийн мөнгийг хэрхэн үр ашигтай зарцуулах шийдвэр гаргалт | - БАХ-уудын хуралд оролцох |
| 2. БАХ бүрийн яаралтай хүмүүнлэгийн тусламж өрхүүдийн тоо, шалгуур | - БАХ-уудын тусламж авсан өрхийн санхүүгийн баримт |
| 3. Хүмүүнлэгийн яаралтай тусламж авсан нь малчдын амьдралд хэрэг болсон эсэх | - БАХ-ууд, малчин өрхүүдээр орж танилцах<br>- Мэдээллийн самбар ажиллуулах<br>- Малчдын мэдээллийн дагуу газар дээр очиж үзэх<br>- БАХ-уудын санхүүгийн баримтыг шалгах, нэгтгэх |
| 4. Зудын бэлтгэл хангуулах үйл ажиллагаанд хэрхэн зарцуулж буй талаар | |

### III.Хэрэгжүүлэлт




### Тусламжийн төслийн мөнгийг юунд зарцуулж болохгүй вэ?

| Н | Хориглох зүйл | |
|---|---|---|
| 1. | Банкны, дэлгүүрийн мөн бусад өр төлбөр төлөх | Санхүүжүүлэгч ШХА-с гаргасан санал |
| 2. | Мал худалдаж авах | |
| Малчид өөрсдийн БАХ-ийн хурал дээр хэлэлцэж дээрхи 2 хориглох зүйлсээс өөр зүйл байвал хүснэгтийг бэлчээр ашиглалтын хэсгийн ахлагч үргэлжлүүлэн бөглөж, тайлбарыг нь бичих шаардлагатай. | | БАХ-н хурал дээр БАХ-н ахлагчийн тайлан, АХ-н тайланг сонсох |
| 3. | | БАХ-н малчдаас гарсан санал |
| 4. | | |

### III. БАХ-ууд зудын төслийг хэрхэн хэрэгжүүлэх вэ?




### Тусламжийн төслийн мөнгийг юунд зарцуулж болохгүй вэ?

3.1. Нэг удаагийн хүмүүнлэгийн тусламж – БАХ-т ирж буй мөнгөний 50%-г зарцуулна

| Хэрхэн | Хэнд | Яаж |
|---|---|---|
| •БАХ-н хурлаар хэлэлцэж доорх шалгуурууудаас гадна тухайн БАХ-н малчдын гаргасан нэмэлт шалгууруудын үндсэн дээр хэн хүмүүнлэгийн яаралтай тусламж авахыг тогтоно. | • Үндсэн шалгуурууд:<br>• Огт малгүй болсон<br>• Малынхаа 70%-с дээш алдсан<br>• Хоёроос дээш олон хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэй, эрэгтэй<br>• БАХ-н үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог | • Бэлэн мөнгөөр өгөх үү<br>• Бараа бүтээгдхүүнээр өгөх үү- хэрэв тийм бол юу ямар хэмжээтэй, юу юу авахаа тогтож сумын Ажлын Хэсгийн худалдан авалтын комисст хүргүүлнэ. |

### Тусламжийн төслийн мөнгийг юунд зарцуулж болохгүй вэ?

3.2. БАХ-н ахлагч малчдаас гарсан санаануудыг бичиж нэн шаардлагатай хамтаараа хэрэгжүүлэх ажлаа оноо өгч эрэмбэлэн хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүний дараа төлөвлөгөөгөө гаргана. (гарын авлагын хүснэгт 8-г бөглөх) – БАХ-т ирж буй мөнгөний үлдэх 50%-г зарцуулна.

| Н | Үйл ажиллагаа | Оноо |
|---|---|---|
| | | |
| | | |
| | | |

### IV.Тайлагнал

**БАХ-ийн тайлан хамтын шийдвэрийн хэрэгжилтийн тайлан**

- Хүмүүнлэгийн тусламжийн ажил
- Зудын гамшгаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт
- БАХ-н ахлагч тусламжийн төслийн зарцуулалтыг БАХ-ын бүх гишүүдийн хуралд орлого, зарлагын гүйлгээ тус бүрээр тайлагнаж хэлэлцүүлнэ.

**Санхүүгийн тайлан:** Сумын ТББ нь санхүүгийн тайлангаа МБМХ-д хүлээлгэн өгнө

- БАХ бүрийн дансанд болон бусад арга хэмжээнд тусламжийн мөнгөн дүнг шилжүүлсэн баримт,
- Өрхөд авч өгсөн бэлэн мөнгө, бараа болон бусад худалдан авсан үйлчилгээ, материалын тоо хэмжээ, түүний санхүүгийн баримт

## 1.2. БАХ-н гишүүн малчдад хүргэх мэдээлэл

## 1.3. Бэлчээр ашиглагчдын хэсгийн зудын хохирлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах

Сумын "Бэлчээр ашиглагчдын холбоо" ТББ-ын тэргүүн нь БАХ-н нутаг дэвсгэр дээрхи малчин өрхүүдийн нэрсийг гаргаж, БАХ-ийн ахлагч нар багийн дарга нартай нэрсийг тулгаж айл өрхүүдийн мэдээллийг орхигдуулахгүй байх талаар анхаарах хэрэгтэй.

Малчин айл өрхүүдийн тоог гаргасны дараа БАХ бүрийн өрхийн тоог эцэслэн гаргана. ШХА-аас олгож буй тусламжийг БАХ-р дамжуулж зудад хамгийн их өртсөн малчдад хүргэх тул суманд байгуулагдсан ***Ажлын Хэсэг, БАХ-н ахлагч*** нарын хамт тухайн нэг БАХ-т хэчнээн төгрөг хуваарилах урьдчилсан төсвийг хэлэлцэж батлана. Төсөв хуваарилах олон аргуудаас дараах жишээнүүдийг үзнэ үү:

***1-р жишээ: Тэгш хуваарилах зарчим***

БАХ-ийн өрхийн тоо, хамгийн их зуданд нэрвэгдсэн малчин өрхийн тоог харгалзахгүйгээр БАХ-т санхүүжилтыг тэгш хувиарлах.

Жишээ нь: Танай сум 5 бэлчээр ашиглагчдын хэсэгтэй бөгөөд тусламжаар нийт 10,000,000 төгрөг хуваарилагджээ. Тэгвэл БАХ болгонд 2,000,000 төгрөг ноогдоно. (10,000,000 Төг : 5 БАХ = 2,000,000)

Энэ арга нь төсөл хэрэгжүүлэгчдэд хамгийн амар арга боловч хамгийн их сул талуудтай. БАХ болгонд өрхийн тоо, зуданд нэрвэгдсэн өрх харилцан адилгүй, хэрэв энэ аргыг хэрэглэвэл төслийн ч, гамшигт нэрвэгдсэн малчдын ч жинхэнэ хэрэгцээг хангаж чадахгүй билээ.

***2-р жишээ: Өрхийн тоонд үндэслэж хуваарилах зарчим***

БАХ-ийн нийт өрхийн тоог харгалзаж, өрхийн тоо ихтэй БАХ-д санхүүжилтыг илүү хуваарилж, өрхийн тоо багатай БАХ-т санхүүжилт бага хуваарилах зарчим юм.

Жишээ нь: Танай сумын БАХ-ийн өрхийн тоо дараах байдалтай гэж үзвэл, эхлээд нийт санхүүжилтийг өрхийн тоонд хувааж нэг өрхөд ноогдох төсвийг гаргана. (10,000,000 Төг : 200 өрх = 50,000 Төг). Нэг өрхөд ноогдох төсвийг БАХ-ийн харгалзах өрхийн тоонд үржүүлж БАХ-д ноогдох нийт төсвийг гаргана.

| № | БАХ-ийн нэр | Өрхийн тоо | Нэг өрхөд ноогдох төсөв | БАХ-д ноогдох нийт төсөв |
|---|---|---|---|---|
| 1 | А | 41 | 50,000 | 2,050,000 |
| 2 | Б | 73 | | 3,650,000 |
| 3 | В | 26 | | 1,300,000 |
| 4 | Г | 45 | | 2,250,000 |
| 5 | Д | 15 | | 750,000 |
| НИЙТ | | 200 | | 10,000,000 |

Энэ аргачлал төгс аргачлал биш гэдгийг анхаарна уу. Дээрх аргачлал нь төсвийг зөвхөн ганц хүчин зүйл (өрхийн тоо) дээр үндэслэж хуваарилж байна. Дээрхи жишээн дээр БАХ В-гийн өрх хамгийн их зуданд малаа алдсан, харин БАХ Б-ийн өрх айлууд хамгийн бага зуданд өртсөн гэж үзвэл, тусламжийн мөнгө шудрага хуваарилагдсан гэдэгтэй хэн ч санал нийлэхгүй бизээ.

***3-р жишээ: Өрхийн тоонд болон зудад өртсөн байдалд үндэслэж хуваарилах зарчим***

Тухайн сумын нутаг дэвсгэр дээр цасан шуурга гамшгийн байдал, зудад өртсөн өрхүүдийн байдал харилцан адилгүй байх тохиолдол байгаа тул Ажлын Хэсэг, БАХ-н ахлагч нарын хамт БАХ-н өрхүүдийн тооноос гадна зудад өртсөн нөхцөл байдлыг хэлэлцэж төсвийг хамгийн оновчтой, төслийн болон малчдын хэрэгцээг хангасан хуваарилалт гаргаж ирэхийг хүсэж байна.

**(Хүснэгт 2) БАХ –д ноогдох тусламжийн хөрөнгийн хуваарь** *(ТББ-н тэргүүн бөглөнө)*

| № | БАХ-ийн нэр | БАХ-ийн ахлагчийн нэр | Малчин өрхийн тоо | БАХ-н өрхүүдийн зудад өртсөн* байдал | Нэг өрхөд ноогдох төсөв | БАХ-д ноогдох нийт төсөв |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| | | | | | | |
| НИЙТ | | | | | | |

*БАХ-н өрхүүдийн зудад өртсөн байдал гэдэгт: БАХ-н нийт өрхийн.... % нь нийт малынхаа 70%-с дээш алдсан, олон хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэй, ганц бие эрэгтэй бүхий өрхийн тоо

Баталсан: ..................................... / /

Төсөв хөрөнгөө баталсаны дараа, ажлын хэсэг хэлэлцэж БАХ тус бүр дээр хурал зохион байгуулах хурлын товыг гаргаж батална. БАХ-ийн хурлыг богино хугацаанд малчдад хүндрэл, дарамт учруулахгүйгээр зохион байгуулна. Хурлыг зохион байгуулахад 2 үе шаттай хэрэгжүүлнэ. 1 дүгээрт хурлын товыг зарлах, 2 дугаарт хурлыг товолсон газар, хугацаанд зохион байгуулах.

БАХ-ийн хурлын товыг дараах хүснэгтэнд бөглөнө:

**(Хүснэгт 3) БАХ-уудын хурлын тов** *(ТББ-н тэргүүн бөглөнө)*

| N | БАХ-ийн нэр | Хуралдах газар */Хаана?/* | Хуралдах хугацаа */Хэзээ?/* | Ажлын хэсгээс БАХ-н хуралд оролцох хүний нэр |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |

БАХ-ийн ахлагч нар хурлын товыг тараахдаа хүнтэй хамтарч зарлаж болох бөгөөд замын зардал, шатахууны зардлыг ТББ-аас урьдчилгаа авч хэрэгжүүлж болно /Санхүүгийн баримтыг сайн бүрдүүлэх ёстойг анхаарна уу! *– Тухайн зар тараасан өрхийн гишүүний зарыг авсан гэсэн гарын үсэг хүснэгт 4-ийн сүүлийн баганад бичигдсэн байна!*

ШХА-аас олгосон тусламжийг малчдын оролцоотойгоор шийдэх тул БАХ-ийн нутаг дэвсгэр дээрхи малчин өрхүүдийн олонхийн төлөөлөл зайлшгүй ирсэн байх бөгөөд бүлэг болон хот айлуудаас нэг төлөөллөө оролцуулж болно.

**Зөвхөн хурлын товыг айлуудаар явж тараахаас гадна, орон нутгийн ЗДТГ-тай хэлэлцэж багийн дарга нартай хамт явах, хүний эмч болон малын эмч дагуулж малчдыг эргэх зэрэг үр бүтээлтэй ажлуудыг хавсарч хийхийг уриалж байна.** Айл өрхүүдээр хурлын зар тараахдаа, тэдний хаваржилтын байдалтай танилцаж баримтжуулах нь бас чухал.

**(Хүснэгт 4) “ ..........................”БАХ-ийн гишүүн өрхийн товч бүртгэл**

... -р сарын .... Өдөр *(/БАХ-н ахлагч энэ хүснэгтийг бөглөнө/)*

| № | Өрхийн тэргүүний нэрс | Ам бүл | Малын тоо | | | | | Хорогдсон малын тоо | | | | | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Тэмээ | Адуу | Үхэр | Хонь | Ямаа | Тэмээ | Адуу | Үхэр | Хонь | Ямаа | |
| | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | |

# БҮЛЭГ ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТ



## 2.1 Хяналтыг бүрдүүлэх

Тусламжийн хөрөнгийг замаас нь завших, хэн нэгэн этгээд эрх мэдлээ ашиглан хөрөнгийг шамшигдуулах зэрэг сөрөг үйл ажиллагаа нь хяналт хангалтгүй, ил тод биш зэргээс шууд хамааралтай нь ойлгомжтой. Тиймээс энэхүү хүмүүнлэгийн зудын төслийг амжилттай, ил тод хэрэгжүүлэх нь малчдын хяналт, сумын “Бэлчээр ашиглагчдын холбоо”-ны хяналт, сумын ажлын хэсгийн хяналт, Монголын Бэлчээрийн Менежментийн Холбооны хяналтаас шалтгаална.

Хяналтыг бүрдүүлэх арга зам:

**1. Малчдын хяналт**

Энэхүү тусламж малчдад зориулсан тул малчид хамтаараа хэлэлцэж, хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа шийдэх тул та нарын хяналт зайлшгүй хэрэгтэй. Энэ нь нэг талаас төслийн үр дүн, үр нөлөөг үнэлэх, нөгөө талаас малчдын байгууллага БАХ-н малчдын хамтын үйл ажиллагаа, сайн засаглалыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

Малчид дараах чиглэлээр хяналт тавьж гарсан зөрчлийн талаар ажлын хэсэг болон Монголын бэлчээрийн менежментийн холбоонд утсаар буюу биечлэн мэдэгдэнэ.

- Малчдын санал оролцоонд тулгуурлаж буй эсэх
- Малчдын хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн арга хэмжээнд зарцуулж буй эсэх
- Ажил үйлчилгээнд зарцуулсан мөнгө нь орон нутгийн үнэ ханштай нийцэж буй талаар
- Зарцуулалтын тайлан ил тод байгаа талаар

***Хяналт тавих арга замууд:***

- БАХ-ийн бүх гишүүд зудын төслийн мөнгөний зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй бөгөөд БАХ-ын дундын мөнгөн хуримтлалыг захиран зарцуулах үйл ажиллагаанд байнга хяналт тавих эрх бүхий Хяналтын Зөвлөл нь зудын тусламжийн төслийн мөнгийг захиран зарцуулах үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг гүйцэтгэж болно.
- Эсвэл зудын төслийн Хяналтын Зөвлөлийг БАХ-ын гишүүд дундаас БАХ дотроо нэр хүнд бүхий, үнэнч шударга, өөрсдийн бүрэн төлөөлөл болохуйц 2-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр (цаашид зөвлөл гэх) гишүүдийн хурлаас сонгоно.

***Хяналтын зөвлөлийн үүргүүд:***

- Хяналтын Зөвлөл нь яаралтай тусламжаар мөнгөн эсвэл бараа материалыг хурлын шийдвэрээр нэр нь цохогдсон өрхүүд авсан эсэхийг хянаж, тэдгээр өрхүүдийн тусламжийг хүлээн авсан баримтыг шалгаж гарын үсгээ зурж давхар баталгаажуулна. Энэ нь санхүүгийн баримтанд хавсаргагдана.
- Зудын гамшгаас хамгаалах бэлтгэл ажилд зарцуулахаар төлөвлөгдсөн мөнгөний зарцуулалтанд хяналт тавьж бүртгэл, бусад шаардлагатай бичиг баримттай танилцах, үр дүнгийн талаархи БАХ-ийн ахлагчийн тайлан, мэдээлэл сонсох, шаардлагатай гэж үзвэл бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах гэх зэрэг эрх эдэлнэ.

**2. Ажлын хэсгийн хяналт**

Төсөл эхлэхээс дуусах хүртэлх хэрэгжилтийн хугацаанд Ажлын хэсгийн гишүүд нийтдээ 3 удаа БАХ-н хурал, малчин өрхүүдээр явж төслийн хэрэгжилт хэрхэн явагдаж байгаа талаар газар дээр нь танилцана.

Үүнд:

**2.1.** Төсөл эхлэхэд БАХ–н хурлуудад төлөөллөөр оролцож төслийн үйл ажиллагааны чиглэлийг өгөх, хэрэгжилтэнд дэмжлэг хэрхэн үзүүлэх талаар танилцуулна.

**2.2.** Төслийн хэрэгжилтийн явцад болон малчдын мэдээлийн дагуу болон БАХ, малчин өрхүүдээс сонгож газар дээр нь үзэж танилцах, асууж лавлах зэргээр тусламжийн үйл ажиллагаа зөв шударга явагдаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгнө.

**2.3.** БАХ-ийн төлөвлөгөө, хурлын протокол, шийдвэрийн дагуу үйл ажиллагаа хэрхэн явагдсаныг төслийн төгсгөлд БАХ бүрийн тайлан болон хяналтын зөвлөлийн гарын үсэг зурсан баримтууд, санхүүгийн баримтанд тулгуурлан харьцуулж тооцоолох, малчин өрхүүдээр орж газар дээр нь үзэж танилцах, асууж лавлах байдлаар хянана.

**3. Мэдээллийн самбар**

Хамгийн чухал нь энэхүү төсөл олон нийтэд ил тод байх ёстой. Тусламжийн хөрөнгө хэрхэн хуваарилсан БАХ-үүд хэрхэн зарцуулахаар төлөвлөсөн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан самбарыг нийтэд харагдахуйц байдлаар гаргаж төслийг дуусах хүртэл үйл явцаар шинэчлэн баяжуулж олон нийтэд нээлттэй ил тод сурталчилахыг ажлын хэсэг хариуцан хэрэгжүүлэх юм.

Мөн БАХ-н ахлагч нар зудын төслөө хэрэгжүүлэх төлөвлөгөөгөө энэ самбар дээр хадаж, хэрэгжилтийн байдлын талаарх мэдээллээ сумын ТББ-н тэргүүнд болон Ажлын хэсгийн гишүүдэд явуулж уг мэдээллийн самбар дээр мэдээлж байна.

Мэдээллийн самбар дээр Монголын бэлчээрийн менежментийн холбооны энэхүү төслийг хариуцсан хүний утас заавал байх ёстой. Малчдын гомдол шүүмжлэлийг бид хүлээж авахад нээлттэй байх болно.

# БҮЛЭГ ГУРАВ. ТУСЛАМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ



### 3.1 Тусламжийн төслийг малчдад танилцуулах хурал

Сумын ажлын хэсгээс гаргасан хуваарийн дагуу БАХ нь малчдын хурлаа зохион байгуулж тусламжийн хөрөнгийг хэрхэн зарцуулах талаар харилцан ярилцаж нээлттэй хэлэлцэх замаар зөвшилцөж хамтын шийдвэр гаргаж хэрэгжүүлнэ. БАХ-ийн нутаг дэвсгэр дээрхи малчин өрхүүдийн олонхийн төлөөлөл зайлшгүй ирсэн байх бөгөөд бүлэг болон хот айлууд дундаасаа нэг төлөөллөө оролцуулж болно. Хурлын бүртгэл хөтөлсөн байна.

**(Хүснэгт 5) БАХ-ийн хурлын протокол** *<u>/БАХ-н ахлагч энэ хүснэгтийг бөглөнө/</u>*

**БАХ-ийн хурлын протокол**

...-р сарын ... өдөр

**................................ БАХ-ийн хурлын протокол**

Хурал болсон газар: ..........................

Хурлын ирц: Нийт ......Хүн, үүнээс: ......эрэгтэй .....эмэгтэй

**(Хүснэгт 6) БАХ-н хурлын гишүүдийн бүртгэл** *<u>/БАХ-н ахлагч энэ хүснэгтийг бөглөнө/</u>*

| N | БАХ-н хуралд оролцсон гишүүний нэр | Гарын үсэг |
|---|---|---|
| 1 | | |
| 2 | | |
| | | |

Энэхүү хурлын үр дүнд малчид дараах ойлголтонд хүрсэн байх ёстой. Үүнд:

1) ШХА-аас санхүүжүүлж буй хүмүүнлэгийн төслийн ач холбогдлыг ойлгох
2) Тусламж хүртэгсдийн нэрсийн жагсаалтыг гаргах
3) Тусламжийн төслийн мөнгийг юунд зарцуулагдахгүйг тодорхойлох
4) Тусламжийн төслийн мөнгийг юунд зарцуулж болохыг тодорхойлох
5) Хэрэгжүүлэх арга замуудыг тодорхойлох
6) Цаашид гарах зудын хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор авах арга хэмжээг тодорхойлох

ШХА-аас санхүүжүүлж буй төслийн танилцуулгыг энэхүү гарын авлагын хуудас 7-9 д буй танилцуулгаас харж малчдад ойлголт өгнө үү.

Энэхүү тусламжийн тодорхой хэсэг нь зуданд хамгийн ихээр нэрвэгдсэн, эмзэг бүлгийн, амьжиргааны эх үүсвэрээ алдсан малчдад хүрэх ёстойг

анхаарна уу. Мөн тодорхой хэмжээ нь цаашид гамшгаас хамгаалахад шаардлагатай арга хэмжээнд зориулагдах ёстойг бодолцоно уу.

**Анхаарах зүйлс:** Энэхүү тусламж малчдыг бэлэнчлэх сэтгэлгээг өөгшүүлэх бус харин, тусламж авсанаар хамтаараа нийлж нийтийг хамарсан шаардлагатай үйл ажиллагааг зохион байгуулах (малын сэг зэмийг нэг доор бөөгнүүлэх, өвөлжөөгөө ариутгах, зам гаргах, г.м.) ёстойг мөн анхаарна уу.

## 3.2 Тусламж хүртэгсдийн нэрсийн жагсаалтыг гаргах

**3.2.1.** БАХ-д хуваарилагдан очиж байгаа тусламжийн мөнгөний 50 хувийг **хүмүүнлэгийн яаралтай тусламж**ийн үйл ажиллагаанд зарцуулна гэж заасан.

Энэ арга хэмжээнд хамрагдах хүмүүсийг хэсгийн хурлаар хэлэлцэж доорх үндсэн шалгууруудаас гадна тухайн хэсгийн малчдын гаргасан нэмэлт шалгууруудын үндсэн дээр шийдвэрлэж хэн яаралтай тусламж авахыг / нэрсийг жагсаана/ тогтоно. Үндсэн шалгуурууд:

1. Огт малгүй болсон
2. Малынхаа70-аас дээш хувийг зудад алдсан
3. Хоёроос дээш хүүхэдтэй, өрх толгойлсон эмэгтэй, ганц бие эрэгтэй хүмүүс
4. ..........

Үүний дараа уг тусламжийг шууд мөнгөн хэлбэрээр өгөх үү, эсвэл бараа бүтээгдхүүн авч өгөх үү гэдгийг тогтож хэрвээ бараа бүтээгдхүүн авах тохиолдолд ямар барааг хэчнээн хэмжээтэй буюу тоо, үнийн хамт тооцож сумын Ажлын Хэсэгт өгнө. Ажлын хэсгээс **Худалдан Авалтын Комиссыг** томилох ба уг комиссын гишүүд БАХ бүрийн хурлын шийдвэрээс гарсан яаралтай тусламж үзүүлэх өрхүүдэд өгөх бараа материалын захиалгыг хүлээн авч тусламжийн барааг бөөнөөр сум, аймгийн төвөөс худалдан авна. Худалдан авсан барааны падаан баримтыг ТББ-д хүлээлгэн өгөх ба тусламжийн барааг БАХ бүрийн ахлагч нарт хүргэж хүлээлгэн өгнө. Тусламжийн барааг БАХ-н ахлагч хүргэж тараан өгөх эсвэл тухайн өрхүүд өөрсдөө БАХ-н ахлагчаасаа очиж авч болно.

**(Хүснэгт 7) Хүмүүнлэгийн яаралтай тусламжийн мэдээлэл**

*/БАХ-н ахлагч энэ хүснэгтийг бөглөнө/*

| N | Тусламжинд хамрагдах өрхийн тэргүү-ний овог, нэр | Өрхийн тэргүүний Хүйс | Ам бүл | Нэг өрхөд ногдох, **төг** | Мөнгөн хэлбэрээр олгох, **төг** | Бараа бүтээгдхүүнээр олгох | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Барааны нэр | Тоо | үнэ |
| | | | | | | 1.......<br>2....... | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |

## 3.3. "Зудын Хохирлыг Бууруулах, Урьдчилан Сэргийлэх" төслийн мөнгийг юунд зарцуулж болохгүй вэ?

ШХА-аас олгож буй тусламжийн мөнгийг доор дурдсан зүйлсэд зарцуулж болохгүйг заасан билээ. Энэхүү тусламж нь малчдад нэн шаардлагатай зүйлсд зарцуулагдах учиртай бөгөөд тусламжийн мөнгө банк болон дэлгүүрийн эздэд орлого оруулахад зориулагдаагүй юм.

Бэлчээрийн даац хэтэрсэн, өвсний гарц буурсанаас болж хадлан бэлдэх мөн мал өвлийг даах хангалттай тарга хүч авахгүй байгааг малчин болгон мэдэж байгаа билээ. Тиймээс малаа чанаржуулах, тоо толгойг бууруулах шаардлагатай энэхүү цаг үед мал худалдаж авахад тусламжийн мөнгө зарцуулагдахгүйг анхаарна уу.

**(Хүснэгт 8) Хориглох зүйлс** *<u>/БАХ-н ахлагч энэ хүснэгтийг бөглөнө/</u>*

| N | Хориглох зүйлс | |
|---|---|---|
| 1. | Банкны, дэлгүүрийн мөн бусад өр төлбөр төлөх | **ШХА-аас гаргасан санал** |
| 2. | Мал худалдаж авах | |
| Малчид өөрсдийн БАХ-ийн хурал дээр хэлэлцэж дээрхи 2 хориглох зүйлсээс өөр зүйл байвал хүснэгтийг бэлчээр ашиглалтын хэсгийн ахлагч үргэлжлүүлэн бөглөж, тайлбарыг нь бичих шаардлагатай. | | |
| 3. | | **БАХ-ийн малчдын хурлаас гарсан санал** |
| 4. | | |
| 5. | | |

Тайлбар:
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................
.............................................................................................................

## 3.4 . "Зудын Хохирлыг Бууруулах, Урьдчилан Сэргийлэх" төслийн мөнгийг юунд зарцуулж болох вэ?

Бэлчээр ашиглалтын хэсгийн хурлаар малчид тусламжийн мөнгийг юунд зарцуулах талаар хэлэлцэж нэн шаардлагатай зүйлсээ хамтаараа хэлэлцэж зарцуулах нь оновчтой. Гэхдээ **Тусламжийн мөнгө юунд зарцуулж болохгүй вэ?** Хүснэгт 5 дээр бичсэн зүйлстэй давхцаж болохгүй билээ.

Энэхүү хүснэгтийг бөглөхдөө:

1-т: Бэлчээр ашиглалтын хэсгийн ахлагч малчдаас гарсан санааг хүснэгтийн ***Болох зүйлс*** – ийн доор цувуулж бичнэ.

2-т: Санаануудаа бичиж дуусаад, хооронд нь харьцуулж оноо өгнө. Оноог өгөхдөө олуулаа хэлэлцэж, 1-ээс 10 хооронд өгөх ёстой. Үүнд нэн шаардлагатай үйл ажиллагаанд 10 оноо, шаардлагагүй гэж үзвэл 1 оноо өгнө.

Онооны эрэмбэ:

| Шаардлагагүй | Бага зэрэг | Дунд зэрэг | Шаардлагатай | Нэн шаардлагатай |
|---|---|---|---|---|
| 1-2 | 3-4 | 5-6 | 7-8 | 9-10 |

Энэ хүснэгтийг бөглөснөөр малчид нэн шаардлагатай байгаа зүйлсээ тодорхойлоход дөхөм болох юм. Мэдээж хүн болгонд хязгааргүй хэрэгцээ байгаа боловч бидний санхүүжилт хязгаартай. Малчид хамтаараа хэлэлцэж хамгийн хэрэгтэй гэсэн зүйлдээ тусламжийн мөнгийг өөрсдөө шийдэж зарцуулна гэдэгт найдаж байна.

**(Хүснэгт 9) Тусламжийн төслийн мөнгийг юунд зарцуулж болох вэ?**

*/БАХ-н ахлагч энэ хүснэгтийг бөглөнө/*

| № | Үйл ажиллагаа | Оноо |
|---|---|---|
| 1. | | |
| 2. | | |
| 3. | | |
| 4. | | |
| 5. | | |

## 3.5 Хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

Тусламжийн төслийн мөнгийг юунд зарцуулах боломжтойг малчид та нар өөрсдөө тодорхойлж, ач холбогдолоор нь оноо өгсөн билээ. Эдгээр үйл ажиллагааг хамгийн их оноогоор нь жагсааж дараах хүснэгтэнд бичиж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулна. Хамгийн их оноотой үйл ажиллагаа нь хамгийн эхэнд бичигдэнэ. БАХ-ийн гишүүд олонхийн саналаар дэмжигдсэн үйл ажиллагаанд тусламжийн мөнгийг зарцуулах юм.

**(Хүснэгт 10) “................” БАХ-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө**

*/БАХ-н ахлагч энэ хүснэгтийг бөглөнө/*

| № | Үйл ажиллагаа | Хугацаа | Төсөв | Хариуцан гүйцэтгэх хүн | Хамтран хэрэгжүүлэх байгууллага хүн | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | | |
| 2 | | | | | | |
| 3 | | | | | | |

Зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг БАХ-д хуваарилагдаж ирсэн тусламжийн хэмжээнээс хэтрүүлэн төлөвлөж болохгүй бөгөөд хэрэгжүүлэх хугацаа, хариуцах эзнийг заавал тусгасан байна.

Хурлын дараа БАХ бүр боловсруулсан төлөвлөгөөнийхөө хувийг сумын ажлын хэсэгт хүргэнэ. Сумын ажлын хэсэг тусламжийн хөрөнгийг хэрхэн хуваариласан, БАХ-үүд хэрхэн зарцуулахаар төлөвлөсөн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг сумын засаг захиргааны байрны гаднах самбарт олон нийтэд нээлттэй сурталчилах болно.

Зудын гамшгийг бууруулах талаар БАХ-ийн хүч, боломж хүрэхгүй буюу бусад БАХ, байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил, үйлчилгээний талаар ажлын хэсэгт мэдэгдэнэ.

БАХ-ийн төлөвлөсөн ажил, үйлчилгээг хуваарийн дагуу, ахлагчаар дамжуулан аливаа саадгүйгээр санхүүжүүлэх ажлыг Сумын Бэлчээр Ашиглагчдын Холбоо ТББ хариуцан хэрэгжүүлнэ.

Явцын дунд БАХ-ийн ахлагч нар ажлын уялдаа холбоог хангах, мэдээлэл солилцох зорилгоор зөвлөлдөнө.

# БҮЛЭГ ДӨРӨВ. ТАЙЛАГНАХ



## 4.1 Үйл ажиллагааны тайлан

БАХ-ийн малчид анхныхаа хурлаар 2 чиглэлийн шийдвэр гаргасан. Үүнд:

- Нэгдүгээрт: тусламжийн мөнгөний 50 хувийг хүмүүнлэгийн яаралтай тусламж хэлбэрээр олгоход хамрагдах өрхийн тоо, ямар хэлбэрээр зарцуулахаа хэлэлцсэн жагсаалт
- Хоёрдугаарт: тусламжийн мөнгөний үлдэх 50 хувийг зудын гамшгаас сэргийлэх арга хэмжээнд зарцуулахаар тооцож арга хэмжээ буюу хийх ажлаа төлөвлөсөн

Дээрхи хоёр шийдвэрийнхээ биелсэн эсэх талаар тайлбарлан бичнэ. Биелээгүй бол ямар учир шалтгааны улмаас хэрэгжээгүйг нэг бүрчлэн тайлбарлана.

..........................................................................................................................
..........................................................................................................................
..........................................................................................................................
